



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



Japan
Fund for
Poverty
Reduction

ХҮЧИТ ТЭЖЭЭЛ

Мал, амьтны төрөл, нас, хүйс, ашиг шимийн онцлогт тохирсон жорын дагуу тэжээллэг чанар сайтай боловч өвөрмөц бүтэцтэй тэжээлийн түүхий эдүүдийг жижиглэн хэрчих, тээрэмдэж нунтаглах, хэмжиж тунлах, хольж багсарах аргаар бэлтгэсэн нэгэн төрлийн бүтэцтэй хольцыг хүчит холимог тэжээл гэнэ. Хүчит тэжээл нь хялбар шингэх нүүрс усны агууламж ихтэй үет ургамрын үр (арвай, улаан буудай, хөх тариа, хошуу будаа эрдэнэшиш) мөн уургийн агууламж ихтэй буурцагт ургамлын үр (вандуй, тэжээлийн шош, шар буурцаг); зэрэг ургамлуудаас бүрддэг.

Ач холбогдол

Нэг кг өвс 0.45-0.47 нэгжтэй тэнцдэг бол нэг кг үр тариа 1.0-1.2 тэжээлийн нэгжтэй тэнцэнэ. Өөрөөр хэлбэл хүчит тэжээлийн шимт чанар нь бүдүүн тэжээлээс 2.0-2.9 дахин тэжээллэг чанартай юм. Хүчит тэжээл нь олдоц бага, үнэ өртөг өндөр байдагаас малчид төдийлөн ашигладаггүй. Хүчит тэжээл нь багсармал холимог тэжээлийн чанарыг сайжруулах үндсэн түүхий эд болдог.

Хүчит тэжээлийг дараах аргаар бэлтгэж малд өгнө

Няцалж жижиглэх. Бүх төрлийн үр тариаг няцалж жижиглээд бага зэрэг чийглэж малд өгөхөд шингэж боловсрохдоо сайнаас гадна чийглэсэн учир ам хамар руу пургиж орохгүй. Ямар ч малд дэвтээгээгүй үр тариаг бүтнээр нь өгч болохгүй.

Чанаж болгох. Үр тариаг 1-2 цаг чанаж болгоод малд малд өгвөл шингэж боловсрохдоо илүү сайн байхаас малын идэмжийг нэмэгдүүлдэг ач тустай.

Чихэржүүлэх. Хувин саванд 2-3кг нунтагласан үр тариан тэжээл хийж дээрээс нь 4-5 л орчим буцалсан халуун ус нэмж зутан болтол сайн хутгаж дулаан газар хучиж тавина. 6-8 цагийн дараа уг тэжээл чихэрлэг амттай болж мал тэжээхэд бэлэн болсон байна. Чихэржүүлсэн тэжээлээр саалийн үнээ, ядарч туйлдсан мал тэжээвэл тохиромжтой

Соёолуулах. Түмпэн саванд үр тариагаа хийж сайн чийглэн дулаан газар байлгасны дараа урьдчилан бэлдсэн дэлгэцэн дээр жигд тарааж дулаан газар тавьж соёолуулна. 6-8 хоносны дараа соёолсон ногоон хэсэг нь 8-10 см болоход мал тэжээнэ. Соёолуулсан тэжээлээр төл мал болон ядарч доройтсон малыг тэжээхэд тохиромжтой.

Исгэх. Саванд 10 кг гяцалсан үр тариа хийгээд дээр нь 15-20 л бүлээн ус нэмж сайтар хутгаж зутагнана. Энэ зутандаа 100-200 нр орчим тэжээлийн эсвэл талхны хөрөнгө хийж дулаан газар хучиж тавина. 7-9 цагийн лараа тэжээл исэж анхилуун үнэртэй сайхан үнэртэй болно. Исгэсэн тэжээл нь уургаар баялаг, шингэж боловсрохдоо сайн. Тэжээлийг ямар ч мал дуртай иддэг.

Дэвтээх. Үр тариагаа хувин, түмпэнд хийж дээрээс нь халуун ус хийж 1-2 хоног байлгана. Дэвтэж хөөсний дараа малд өгнө. Хүчит тэжээлээр малд тэжээхдээ малын ашиг, шимийн

байдал, нас, хүйс, амьдын жинд тохируулан тогтоосон хэмжээг баримтлана. 1 килограмд улаан буудай 166 гр, хошуу будаа 112 гр, бог будаа 102 гр, арвай 81 гр, эрдэнэ шиш 78 гр уурагтай байна.

Хивэг. Манай орны гурилын үйлдвэрээс гарч байгаа улаан буудайн 1 кг хивгээс 0,61 тэжээлийн нэгж, 98 гр шингэн уураг, 0,2 гр кальци, 94нр фосфортой байдаг учир өвөл, хаврын үед эцэж ядарсан болон хээлтэй мал, саалийн гнээ, тал тэжээхэд тохиромжтой. Хивгээр мал тэжээхдээ дангаар чийглэн өгөх, бусад тэжээлтэй хольж өгнө. Хивэгийг өвлийн улиралд саалийн үнээнд 2-4 кг, бяруунд 0,5-1 кг, хонинд 0,4 кг хүртэл өгч болно.

Хивгээр мал тэжээх. Хивгийг малд өгөхдөө чийглэх, исгэх, зутагнах зэргээр боловсруулбал тэжээллэг чанар сайн.

- Чийглэх: Хивгийг давстай усаар чийглэж багсран дангаар нь буюу бусад тэжээлтэй хольж, бод малд өдөрт 1-2 шанага, бог малд 2 аяга өгнө.
- Исгэх: 10 кг хивгэнд 15 л ус хийж 8-10 хоолны халбага тэжээлийн хөрөнгө нэмж хутгаад 6-9 цаг байлгахад иснэ.
- Зутагнах: 10 л усанд 2 кг хивэг хийж, 5 минут буцалган зөөгшүүлж зутан бэлтгэж бог малд 1 аяга, бодод 2-3 аяга өгнө.

Мал тэжээх тооцоо

Малын төрөл	Мал тэжээх тооцоо
Үхэр	1-2 кг
Бяруу	500 гр
Хээлтэй болон төлөлсөн хонь, ямаа	500 гр
Хурга ишиг, төлөг борлон	100-300 гр

Боловсруулсан: МААЭШХ-ын эрдэм шинжилгээний ажилтан Д.Сангажав